



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.03 № МХГ/666
танай _____-ны № _____-т


Асуулгын хариу хүргүүлэх
тухай

Танаас 2026 оны 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн төрийн албан хаагчдын цалингийн талаарх асуулгын хариуг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлснийг Танд үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 02 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265003165



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨ ТӨЛӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЫН САЙД

Нэгдсэн үндсэн гудамж 5
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 16160
Утас: 26-15 7 000 32-86 34
Цахим шуудан: 100 0000 000000
Цахим хуудал: 100 0000 000000

2026.03.02

01/640

төний _____ 1 2 _____ -1

Г _____

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлээс ирүүлсэн асуулгын хариуг ирүүлэх тухай ХЭГ/485 тоот албан бичигтэй танилцан дараах хариуг хүргүүлж байна.

Асуулга 1-ийн хариулт: Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, цалин хөлсний бүтцийг оновчтой болгох чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ирсэн. 2026 оны хувьд эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын хэлэлцээрийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үндсэн цалинг 15-50 хувиар нэмэгдүүлээд байна.

Мөн хүн амын нягтаршил, үзүүлж буй үйлчилгээний тоо зэргийг харгалзан нийслэл, дүүргийн төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Одоогийн байдлаар нийт төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.

Цаашид эдийн засгийн нөхцөл байдал, улсын төсөвтэй уялдуулан бусад салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Түүнчлэн манай яамнаас төрийн албан хаагчийн цалин хөлсний нэгдсэн тогтолцоог бий болгох, цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой салбарын хуулиудаар ялгаатай, харилцан адилгүй тусгагдсан заалтуудыг нэг мөр цэгцлэх, давхардлыг арилгах, шалгуур үзүүлэлт, хамрах хүрээг нэг жишигт нийцүүлэхээр "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай" хуулийн төслийг боловсруулаад байна.

Асуулга 2-ын хариулт: "Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээр"-ийн нэмэлт хэлэлцээрээр багш, ажилтны үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувиар, "Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын /тариф/-ын хэлэлцээр"-ийн нэмэлт хэлэлцээрээр эмч, ажилтны үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 хувиар, Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хоорондын 2026-2028 оны хамтын хэлэлцээрээр шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 2026 онд 50-иас багагүй хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон. Үүний дагуу холбогдох сайд нар салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэх шийдвэрийг гаргаад байна. Тухайлбал ерөнхий боловсролын

сургуулийн багшийн үндсэн цалин 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 742.0 мянган төгрөгөөр, их эмчийн үндсэн цалин 445.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

Асуулга 3-ын хариулт: Салбарын хамтын хэлэлцээрээр цалин хөлсийг нэмэгдүүлснээс бусад салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, зайлшгүй шаардлагатайгаас бусад сул орон тоонд албан хаагч нэмж авахгүй байх, үр ашиггүй зардлыг багасгах, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах зэрэг арга хэмжээ авах замаар 2026 оны батлагдсан төсөвтөө багтаан нэмэгдүүлэх боломжийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосон.

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн, албан хаагчид нь төрийн мэргэжлийн үйлчилгээний бусад байгууллагын албан тушаалын зэрэглэлд хамаардаг бөгөөд уг зэрэглэлд мөн архивч, лабораторийн ажилтан, нягтлан бодогч зэрэг мэргэжлийн үйлчилгээний албан тушаалууд багтдаг тул цалин хөлсийг тусгайлан авч үзэхэд хүндрэлтэй юм. Харин албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлыг салбарын хууль тогтоомж, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Асуулга 4-ийн хариулт: Орон нутгийн нэмэгдлийг хөдөө орон нутагт мэргэжилтэй боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, соёл зэрэг нийгмийн суурь үйлчилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид 2001 оноос олгож эхэлсэн.

Улмаар төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчид орон нутагт тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг баталгаажуулах зорилгоор төрийн захиргааны албан хаагчид 2023 оноос, төрийн үйлчилгээний нийт албан хаагчид болон улс төрийн албан хаагчид 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр олгож эхэлсэн. Ингэснээр хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад сар бүр үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож орон нутгийн нэмэгдэл олгож байна. Тодруулбал, орон нутгийн нэмэгдлийг өмнө нь авдаггүй байсан төрийн нийтлэг үйлчилгээний болон төрийн мэргэжлийн үйлчилгээний зарим албан хаагчид, улс төрийн албан хаагчид 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр авч эхэлсэн.

Уг нэмэгдлийг орон нутаг, алслагдсан гурван дүүргийн төрийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа 115.0 мянга орчим албан хаагчид олгоход улсын төсвөөс жилд дунджаар 417.0 тэрбум төгрөг зарцуулж байна.

Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэх эрхийг олгож, улсын төсвөөс болон орон нутгийн төсвөөс олгох орон нутгийн нэмэгдлийг тухайн байгууллагын удирдлагын зохион байгуулалтыг (хэвтээ болон босоо) үл харгалзан олгохоор тус тус шийдвэрлэсэн.



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Сайд
Т.Аубакир
2026.03.02 10:38